



2021 оны 05 дугаар сарын 12  
№18 /1168/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



## تذکرہ

### یمنیہ ایچ ایم آر یمن

97006	تذکرہ ایچ ایم آر یمن	• 9706
97006	تذکرہ ایچ ایم آر یمن	• 9706
97006	تذکرہ ایچ ایم آر یمن	• 9706
97006	تذکرہ ایچ ایم آر یمن	• 9706
97006	تذکرہ ایچ ایم آر یمن	• 9706
97006	تذکرہ ایچ ایم آر یمن	• 9706
97006	تذکرہ ایچ ایم آر یمن	• 9706
97006	تذکرہ ایچ ایم آر یمن	• 9706
97006	تذکرہ ایچ ایم آر یمن	• 9706

**ГАРЧИГ**  
**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

162.	Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай	1423
163.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	1425
164.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1426

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

165.	Ерөнхийлөгчийн хоригийн тухай	Дугаар 39	1428
------	-------------------------------	-----------	------

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

166.	Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай	Дугаар 47	1429
167.	Элчин сайдыг эгүүлэн татах тухай	Дугаар 80	1430

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

168.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 05	1431
------	-----------------------------	-----------	------



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 04 дүгээр  
сарын 23-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫГ ХӨНГӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Импортоор оруулж байгаа хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгаа, хүлэмжийн тоног төхөөрөмж, ойн болон шувууны аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг гаалийн албан татвараас 100 хувь хөнгөлсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан барааны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийн үйлчлэл дуусах хүртэл хугацаанд импортоор оруулж байгаа хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгаа, хүлэмжийн тоног төхөөрөмж, ойн болон шувууны аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодист тухайн онд ногдуулан төлсөн гаалийн албан татварыг төсвийн дараагийн жилийн эхний улиралд татвар төлөгчид буцаан олгоно.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**



Үснэгт 1. Үснэгт 1. Үснэгт 1

Үснэгт 1. Үснэгт 1

Үснэгт 1. Үснэгт 1

Үснэгт 1. Үснэгт 1

Үснэгт 1. Үснэгт 1

Үснэгт 1. Үснэгт 1

Үснэгт 1. Үснэгт 1

Үснэгт 1. Үснэгт 1

Үснэгт 1. Үснэгт 1

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 04 дүгээр  
сарын 23-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Импортоор оруулж байгаа болон дотоодод борлуулсан хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, усалгаа, хүлэмжийн тоног төхөөрөмж, ойн болон шувууны аж ахуйн техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодисыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан барааны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Урьдчилсан үзэмжээр үг

᠖᠒᠐᠒᠐ он ᠑᠐ э ᠒᠐᠒᠐ он ᠐᠑ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒

Нийслэл, улсын төсвийн захирлын үйлчилгээний төв  
Хурлын дарга

᠖. Көрүн Хүндэтгэл, Төрийн захирлын үйлчилгээний төв, Урьдчилсан үзэмжээр үг  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒

᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒

᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒  
᠑᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒ - ᠒᠐᠒᠐ он ᠑᠒

Урьдчилсан үзэмжээр үг  
Хурлын дарга



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 04 дүгээр  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт:**

“3.1.2. “нэр дэвшигч” гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэг, энэ хуульд заасан шаардлагыг хангаж Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшин бүртгүүлж, нэр дэвшигчийн үнэмлэх авсан Монгол Улсын иргэнийг;”

#### **2/5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг:**

“5.4. Энэ хуулийн 3.1.2-т заасан шаардлага хангасан, Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаагүй Монгол Улсын уугуул иргэн зөвхөн нэг удаа Ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

*/Энэ хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан./*

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**







## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04 дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 39

Улаанбаатар  
хот

### Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 02 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын 38 дугаар тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2. Энэ тогтоолыг 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

Үсэнтэй, бичиг, мөхрөл, хураангуй, үсэнтэй, бичиг, мөхрөл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ  
2021 оны 04 сарын 29 - өдөр  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Үсэнтэй, бичиг, мөхрөл, хураангуй, үсэнтэй, бичиг, мөхрөл  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ  
2021 оны 04 сарын 29 - өдөр  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ  
2021 оны 04 сарын 29 - өдөр  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ  
2021 оны 04 сарын 29 - өдөр  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Үсэнтэй, бичиг, мөхрөл  
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 03 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.11, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Дашдоржийн Мөнхөөг Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Магнайбаярын Мөнхдавааг Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Бямбаюугийн Цолмонг Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Хөхөөгийн Санжидмааг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Нямжавын Гэрэлтуяаг Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Хурметханы Тасхыныг Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Хүрэлчөдөрийн Отгонжаргалыг Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ганзоригийн Энхтунгалагийг Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Жавзмаагийн Байгалмааг Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус шилжүүлэн томилсугай.

2. Адил шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шилжүүлэн томилсон тул шүүгч Дашдоржийн Мөнхөөг Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Магнайбаярын Мөнхдавааг Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Бямбаюугийн Цолмонг Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Хөхөөгийн Санжидмааг Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан



шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Нямжавын Гэрэлтуяаг Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Хурметханы Тасхыныг Хэнтий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Хүрэлчөдөрийн Отгонжаргалыг Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Ганзоригийн Энхтунгалагийг Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Жавзмаагийн Байгалмааг Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 04 дүгээр  
сарын 02-ны өдөр

Дугаар 80

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ёндонгийн Отгонбаярыг эгүүлэн татсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 01 дүгээр  
сарын 06-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар  
хот

### Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Улсын аварга малчин өрх, улсын хошой аварга малчин өрх шалгаруулах журам”-ыг 1 дүгээр хавсралт, “Улсын аварга фермер шалгаруулах журам”-ыг 2 дугаар хавсралт, “Улсын аварга саальчин шалгаруулах журам”-ыг 3 дугаар хавсралт, “Улсын аварга тариаланч хамт олон, Улсын аварга тариаланч шалгаруулах журам”-ыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан шагналд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт даалгасугай.

3. Малын тоог бэлчээрийн даацад тохируулан бэлчээрийг зохистой ашигласан, малын чанарыг сайжруулж нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлсэн, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малаа бүрэн хамруулсан, эрүүл чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, тэдний нийгэмд оруулж байгаа хувь нэмэр зэрэг шалгуур үзүүлэлтээр орон нутагтаа тэргүүлсэн малчин өрх, саальчин, фермерийг шалгаруулан шагнаан урамшуулж байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 202 дугаар тогтоол, “Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 338 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**У.ХҮРЭЛСҮХ**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

**З.МЭНДСАЙХАН**

Засгийн газрын 2021 оны 5 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

## **УЛСЫН АВАРГА МАЛЧИН ӨРХ, УЛСЫН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН ӨРХ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх, мал маллагааны уламжлалт аргыг боловсронгуй болгох, малын үүлдэрлэг байдал чанарыг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэх, малыг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулах, малчдын нийгэмд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Энэ журамд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан малчдын ажлын үзүүлэлтийг үндэслэн улсын аварга малчин өрх, улсын хошой аварга малчин өрхөөр тус тус шалгаруулна.

1.3. Улсын аварга малчин өрх, улсын хошой аварга малчин өрхөд шагнал олгох шийдвэрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар гаргана.

### **Хоёр. Шагналд тодорхойлогдох малчин өрхөд тавигдах шаардлага**

2.1. Улсын аварга малчин өрхөөр шагнуулахаар тодорхойлогдох малчин өрх нь дараах шаардлагыг хангасан байна.

2.1.1. мал сүргээ жилийн дөрвөн улиралд өөрөө малладаг, мал маллагааны туршлагаа залуу малчдад зааж сургаж шавь малчинтай болсон, түр болон байнгын ажлын байрыг бий болгож орон нутагт ядуурлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулсан байх;

2.1.2. өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржааны хашаа, худагтай байх, мал аж ахуйн үйлдвэрлэлээс олсон орлогоос доройтсон бэлчээрийг сайжруулах, худаг гаргах, булаг, шандны эхийг хамгаалахад зарцуулсан байх;

2.1.3. өвөлжөө, хаваржааныхаа бэлчээрийг гэрээгээр ашигладаг, бэлчээрийн даацад малын тоог тохируулан сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг сэлгэн өнжөөх, отор,

нүүдэл хийх зэргээр зохистой ашигладаг, бэлчээрийн хортон мэрэгч, шавжтай энгийн механик болон микробиологийн аргаар тэмцэх ажилд идэвхтэй оролцдог байх;

2.1.4. ашиглагдахгүй байгаа алслагдсан бэлчээрийг ашиглан отор нүүдэл хийж, малдаа тарга хүч авахуулсан, сумын тухайн жилийн бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу бэлчээрийг ашиглаж зөрчил гаргаагүй байх;

2.1.5. малаа оторлон тарга хүч авахуулдаг, өвөлжилт, хаваржилтад шаардлагатай өвс, тэжээлийг ойт хээрийн бүсэд хонин толгойд шилжүүлснээр нэг малд 50 кг, өндөр уулын бүсэд 20 кг, тал хээрийн бүсэд 40 кг, говийн бүсэд 5 кг байхаар тооцож жил бүр бэлтгэж нөөцөлдөг байх;

2.1.6. тухайн бүс нутагт үржүүлэхийг зөвшөөрсөн төрөл, ашиг шимийн чиглэлийн үүлдэр, омгийн малыг өсгөн үржүүлдэг, малын чанарыг сайжруулах, сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэх чиглэлээр сумын Хөдөө аж ахуйн тасаг, Мал үржүүлэг, технологийн нэгжтэй хамтран ажилладаг, түүнийг баталгаажуулсан мэргэжлийн байгууллагын тодорхойлолттой байх;

2.1.7. мал үржүүлэг, технологийн нэгжтэй гэрээ байгуулж, мал сүрэгтээ үзлэг ангилалтыг технологийн хугацаанд жил бүр тогтмол хамруулсан тухай баталгаажуулалтыг Мал үржүүлэг, технологийн нэгж болон сумын Хөдөө аж ахуйн тасгаас авсан байх;

2.1.8. нийт малыг дахин давтагдахгүй хувийн дугаараар ялган тэмдэглэж бүртгэлжүүлсэн, үржлийн малын удам гарваль, ашиг шим, үр төлийн чанарын үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн тухай баталгаа, үржлийн удам гарвалын гэрчилгээг сумын Хөдөө аж ахуйн тасгаас авсан байх;

2.1.9. бог малын хээлтүүлэгчийг Мал үржүүлэг, технологийн нэгжид ялган төвлөрүүлж, чанар стандартын шаардлага хангасан, удам зүйн үнэлгээнд хамрагдсан хээлтүүлэгчийг мэргэжлийн байгууллага, мэргэжилтний хяналтанд ашигладаг байх;

2.1.10. малын чанарыг сайжруулах, сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, малын тоог бэлчээрийн даацад тохируулах чиглэлээр сумын хөдөө аж ахуйн болон мал эмнэлгийн тасагтай хамтран ажилласан тухай тодорхойлолттой байх;

2.1.11. сүрэгт эзлэх хээлтэгчийн тоо сүүлийн 3 жил дараалан тогтвортой өссөн, хээлтэгч нь бог малд 55, бод малд 40 болон түүнээс дээш хувьд хүрсэн, сүргийн бүтцийг зохистой түвшинд хангасан, бодод шилжүүлснээр 100-аас доошгүй толгой малтай байх;

2.1.12. малаа мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тогтмол, бүрэн хамруулж, малын эрүүл мэндийн дэвтэр хөтөлдөг, сүүлийн 3 жилд мал сүрэгт нь малын гоц халдварт болон халдварт өвчин гараагүй, малын зүй бус хорогдолгүй;

2.1.13. малчин өрхийн гишүүд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд даатгуулж, малын индексжүүлсэн даатгалд малаа даатгуулсан байх;

2.1.14. сүрэгт эзлэх таваарын малаа жил бүр эдийн засгийн эргэлтэд оруулсан байх.

2.2. Малчин өрхийн малын тоо, зах зээлд нийлүүлсэн бүтээгдэхүүний дүнд бусдаас худалдаж болон бэлгэнд авсан мал, бүтээгдэхүүнийг оруулж тооцохгүй.

### **Гурав. Улсын аварга малчин өрх, улсын хошой аварга малчин өрх шалгаруулах**

3.1. Сумын Засаг даргын Тамгын газар нь аймгийн аварга малчин өрхөөр шалгарснаас хойш 3-аас доошгүй жил амжилттай ажилласан, энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа тус бүр нэг малчныг улсын аварга малчин өрх, улсын хошой аварга малчин өрхөөр шалгаруулахаар тодорхойлно. Малчин өрх нь энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгааг нотлох бичиг баримтыг багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэр, сумын Засаг даргын тодорхойлолтын хамт аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

3.2. Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага нь сумдаас улсын аварга малчин өрх, улсын хошой аварга малчин өрхөд тодорхойлж ирүүлсэн малчны холбогдох бичиг баримтыг хянан үзээд аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, хамгийн өндөр үзүүлэлттэй нэг малчин өрхийн тодорхойлолтыг жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.3. Энэ журмын 3.2-т зааснаас бусад аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага нь сумдаас энэ журмын 3.1-д заасны дагуу ирүүлсэн бичиг баримтыг хянан үзээд аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, улсын аварга малчин өрхөөр хамгийн өндөр үзүүлэлттэй 3 хүртэлх малчин өрхийн тодорхойлолтыг, улсын хошой аварга малчин өрхөөр 1 малчин өрхийн тодорхойлолтыг жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4. Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймгаас 3 жил тутамд нэг аварга малчин өрхийг бусад аймгуудаас жил бүр нэг малчин өрхийг улсын хошой аварга малчин өрхөд тодорхойлж ажлын үзүүлэлтийг 5 жилээр гаргаж ирүүлнэ.

3.5. “Улсын аварга малчин өрх”-өөр жил бүр 60 хүртэлх, “Улсын хошой аварга малчин өрх”-өөр 8 хүртэлх тооны малчин өрхийг шалгаруулна.

3.6. Улсын аварга малчин өрх, улсын хошой аварга малчин өрхийг тодорхойлохдоо дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна:

3.6.1. малчны (эхнэр, нөхөр) товч анкет (Хүснэгт 1-ийн дагуу);

3.6.2. ажлын үзүүлэлт (Хүснэгт 2-ын дагуу);

3.6.3. холбогдох тодорхойлолт, баримт бичиг (Хүснэгт 3-ын дагуу).

3.7. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аймгуудаас ирүүлсэн бичиг баримтыг хянаж, дүгнэлт гарган хамгийн өндөр үзүүлэлт бүхий малчин өрхийг улсын аварга малчин өрх, улсын хошой аварга малчин өрхөөр шалгаруулахаар холбогдох материалыг саналын хамт зохих журмын дагуу Засгийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

3.8. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.7-д заасны дагуу санал хүргүүлэхдээ 1 тэмээчин өрхийг улсын аварга малчин өрхөөр шалгаруулахаар холбогдох материалыг саналын хамт зохих журмын дагуу Засгийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

3.9. Энэ журам батлагдахаас өмнө улсын сайн малчин, улсын аварга малчин, улсын хошой аварга малчин цолоор шагнагдсан малчныг “Улсын аварга малчин өрх”, “Улсын хошой аварга малчин өрх” шагналтад адилтган үзнэ.





3.10. Улсын аварга малчин өрх цолоор шагнагдсанаас хойш 5 жил дараалан өмнөх амжилтаа бататгасан малчныг улсын хошой аварга малчин өрхөд тодорхойлж болно.

### **Дөрөв. Шагнал олгох**

4.1. “Улсын аварга малчин өрх”, “Улсын хошой аварга малчин өрх”-ийг тус бүр 4.0 (дөрвөн) сая төгрөгт багтаан цом, энгэрийн тэмдэг, үнэмлэх, гуулин бүслүүртэй модон хувин, хадаг, өргөмжлөл, тууз, улаан халз бүхий таван ханатай гэр, бусад зүйлсээр шагнана. Малчны хотонд шагналын гэрийг тээвэрлэн хүргэх зардлыг тухайн аймаг хариуцна.

4.2. “Улсын аварга малчин өрх”, “Улсын хошой аварга малчин өрх”-д олгох цом нь 30 см өндөртэй, 32 см өргөнтэй, өлзий болон цэцгэн хээгээр чимэглэсэн ширээ хэлбэрийн суурьтай, бадамлянхуа цэцгэн хээ бүхий тавцантай, их биеийн дээд хэсэгт алтан соёмбо, төв хэсэгт төрийн сүлд байршуулсан, доод хэсэгт нь “Улсын аварга малчин өрх” гэсэн бичвэрийг оны хамт товойлгож бичсэн, их биеийн ар талыг түмэн насан хээгээр чимэглэж “Монгол Улсын Засгийн газраас дурсгав” гэж бичсэн байна.

4.3. Улсын аварга малчин өрх, улсын хошой аварга малчин өрх шагналаар шагнагдсан малчны өвөлжөө, хаваржааг “Улсын аварга малчин .....”, “Улсын хошой аварга малчин.....” (овог, нэр бичнэ) гэж хаягжуулж алдаршуулах асуудлыг тухайн сумын Засаг даргын Тамгын газар хариуцна.

4.4. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрөөс өмнө гардуулна.

4.5. Улсын аварга малчин өрх, улсын хошой аварга малчин өрхийн шагнал гардуулах ажлыг Засгийн газрын гишүүд аймаг, сумын төвд нэгдсэн байдлаар зохион байгуулж аварга малчин өрхийг алдаршуулна.

Хүснэгт 1

Цээж зураг

/6x4/,

өнгөт

“УЛСЫН АВАРГА МАЛЧИН ӨРХ”, “УЛСЫН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН ӨРХ”-д ТОДОРХОЙЛЖ БАЙГАА  
МАЛЧНЫ ТОВЧ АНКЕТ

..... он .....сар..... өдөр

1.	Аймаг, сум, багийн нэр	
2.	Ургийн овог (эхнэр, нөхөр)	
3.	Эцгийн (эх) нэр	
4.	Нэр	
5.	Төрсөн он, сар, өдөр, нас, хүйс	
6.	Боловсрол	
7.	Ам бүлийн гишүүдийн тоо	
8.	Улсад ажилласан жил	
9.	Үүнээс малчнаар ажилласан жил	
10.	Сумын аварга малчнаар шалгарсан үнэмлэхийн дугаар огноо	
11.	Аймгийн аварга малчнаар шалгарсан үнэмлэхийн дугаар огноо	
12.	Шагнагдсан төрийн одон, медаль, огноо	

Хүснэгт 2

“УЛСЫН АВАРГА МАЛЧИН ӨРХ”, “УЛСЫН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН ӨРХ”-д ТОДОРХОЙЛЖ БАЙГАА.....АЙМАГ  
.....СУМЫН МАЛЧНЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

..... он..... сар..... өдөр

Үзүүлэлт	Малын төрөл	Онууд		
		.... он	.... он	.... он
Нэг. Малын төрөл, тоо				
Малын үүлдэр, омог (тэмээ.....үүлдэр, омог, адуу ..... үүлдэр, омог, үхэр..... үүлдэр, омог, хонь..... үүлдэр, омог, ямаа.....үүлдэр, омог)				
1. Оны эхний мал    Үүнээс:	Бүгд			
	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			



2. Хээлтэгч	Бүгд			
Үүнээс:	Ингэ			
	Гүү			
	Үнээ			
	Эм хонь			
	Эм ямаа			
3. Хээлтүүлэгч	Бүгд			
Үүнээс:	Буур			
	Азарга			
	Бух			
	Хуц			
	Ухна			
4. Бойжуулсан төл	Бүгд			
Үүнээс:	Ботго			
	Унага			
	Тугал			
	Хурга			
	Ишиг			
5. Зах зээлд борлуулсан мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
6. Үржилд худалдсан мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
7. Малжуулахад өгсөн мал	Бүгд			
Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
8. Оны эцэст тоологдсон мал	Бүгд			



Үүнээс:	Тэмээ			
	Адуу			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
9. Оны эцэст байгаа хээлтэгч	Бүгд			
Үүнээс:	Ингэ			
	Гүү			
	Үнээ			
	Эм хонь			
	Эм ямаа			
10. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо	Буур			
	Азарга			
	Бух			
	Хуц			
	Ухна			
Хоёр. Малын ашиг шим ашиглалтын байдал				
2.1. Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах (кг-аар)	Тэмээний мах			
	Адууны мах			
	Үхрийн мах			
	Хонины мах			
	Ямааны мах			
	Нийлбэр			
2.2. Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн ноос, ноолуур (кг-аар)	Тэмээний ноос (кг)			
	Хонины ноос (кг)			
	Ямааны ноолуур (кг)			
	Нийлбэр			
2.3. Үйлдвэрлэсэн сүү, сүүн бүтээгдэхүүн	Цагаан идээ (кг)			
	Сүү (литр)			
	Нийлбэр			
2.4. Амьд мал борлуулснаас олсон орлого (мян.төг)	Адуу			
	Тэмээ			
	Үхэр			
	Хонь			
	Ямаа			
	Нийлбэр			



2.5. Бүтээгдэхүүнээс олсон нийт орлого (мян.төг)	Мал борлуулснаас			
	Мах борлуулснаас			
	Ноос борлуулснаас			
	Ноолуур борлуулснаас			
	Цагаан идээ борлуулснаас			
	Сүү борлуулснаас			
	Арьс борлуулснаас			
	Шир борлуулснаас			
	Нийлбэр			
<b>Гурав. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн материаллаг бааз</b>				
3.1. Өрхийн хэмжээнд бэлтгэсэн өвс, гар тэжээл, хүчит тэжээл, хужир (тн)	Өвс			
	Гар тэжээл			
	Хүчит тэжээл			
	Хужир			
3.2. Хашаа (өвөлжөө, хаваржаа)	Хашааны тоо			
	Багтаамж (толгой мал)			
3.3. Инженерийн хийцтэй худаг болон гар худаг	Худгийн тоо			
	Хүчин чадал (л/сек)			
3.4. Хөрөнгө оруулалт (мянган төгрөг)	Худаг			
	Малын хашаа, хороо			
	Бэлчээр сайжруулах			
	Хадлангийн талбай хамгаалах			
<b>Дөрөв. Татвар болон эрүүл мэнд, нийгмийн даатгал төлөлт</b>				
4.1. Татвар төлөлт (ХХОАТатвар)	Төгрөгөөр			
4.2. Малын индексжүүлсэн даатгал	Даатгуулсан малын тоо			
	Төлсөн хураамж			
4.3. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Төгрөгөөр			
4.4. Нийгмийн даатгалын шимтгэл	Төгрөгөөр			
<p>Тайлбар: Дээрх үзүүлэлтүүдийг улсын мал тооллого, бусад холбогдох материалыг үндэслэн баталгаажуулна.</p> <p>----- аймаг -----сумын Засаг дарга -----/...../</p> <p>Хөдөө аж ахуйн тасгийн дарга -----/...../</p>				



“УЛСЫН АВАРГА МАЛЧИН ӨРХ”, “УЛСЫН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН  
ӨРХ” ШАГНАЛД ТОДОРХОЙЛОГДСОН .....АЙМАГ.....  
СУМЫН МАЛЧНЫ ТОДОРХОЙЛОЛТ, БАРИМТ БИЧИГ

..... он..... сар..... өдөр

“Улсын аварга малчин өрх”, “Улсын хошой аварга малчин өрх”-өөр  
тодорхойлж байгаа малчин өрх дараах бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ:

1. Малчны ажил байдлын тодорхойлолт;
2. Иргэний үнэмлэхийн хуулбар;
3. Малын А дансны хуулга сүүлийн 3 жилээр;
4. “Сумын аварга малчин”-ы үнэмлэхийн хуулбар;
5. “Аймгийн аварга малчин”-ы үнэмлэхийн хуулбар;
6. Улсын хошой аварга малчин өрхөөр тодорхойлох тохиолдолд  
“Улсын аварга малчин”-ы үнэмлэхийн хуулбар;
7. Малын эрүүл мэндийн дэвтрийн хуулбар;
8. Өрхийн гэр бүлийн гишүүдийн нийгмийн даатгал төлсөн тухай  
цахим лавлагаа;
9. Өрхийн гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн даатгал төлсөн  
тухай цахим лавлагаа;
10. Малын индексжүүлсэн даатгалын гэрээний хуулбар, мөнгө  
төлсөн баримт;
11. Малчин үржлийн малдаа үзлэг ангилалт хийлгэсэн тухай  
сумын Хөдөө аж ахуйн тасгийн тодорхойлолт;
12. Малчин малаа мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга  
хэмжээнд бүрэн хамруулсан тухай сумын Мал эмнэлгийн тасгийн  
тодорхойлолт;
13. Багийн иргэдийн Нийтийн Хурлын тэмдэглэл;
14. Сумын Засаг даргын албан хүсэлт;
15. Аймгийн ХХААГазрын шалгаруулалт хийсэн тухай дүгнэлт;
16. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр, Засаг  
даргын албан хүсэлт;

Засгийн газрын 2021 оны 5 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

## **“УЛСЫН АВАРГА ФЕРМЕР” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Өндөр ашиг шимт мал, амьтан өсгөн үржүүлж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлж байгаа эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийг урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэ журамд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан эрчимжсэн аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг үндэслэн улсын аварга фермерээр шалгаруулна.

1.3. Улсын аварга фермерээр шалгаруулан шагнах шийдвэрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар гаргана.

### **Хоёр. Фермерт тавигдах шаардлага**

2.1. Улсын аварга фермерээр шагнуулахаар тодорхойлогдох эрчимжсэн аж ахуй эрхлэгч нь дараах шаардлага хангасан байна:

2.1.1. байгаль орчинд сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа эрхэлж, орчны ариун цэвэр, эрүүл ахуй, халдваргүйжилтийг шийдвэрлэсэн, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх;

2.1.2. мал, амьтныг эрсдэлээс хамгаалах даатгалд хамруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл тогтмол төлсөн байх;

2.1.3. гоц халдварт болон халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малаа бүрэн хамруулж, мэргэжлийн байгууллагаар эрүүл сүрэгтэйгээ баталгаажуулсан байх;

2.1.4. мал бүрийг ээмэгжүүлж, бүртгэлжүүлсэн, үржилд ашиглаж байгаа малын анги, ашиг шимийн гарц, чанарыг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байх;

2.1.5. мал үржлийн алба болон хэрэглэгчийн захиалгаар үржлийн мал, амьтан бойжуулж, нийлүүлсэн байх;



2.1.6. эрчимжсэн аж ахуй эрхэлж байгаа туршлагаа залуу малчдад эзэмшүүлэх талаар санаачилга гарган ажиллаж 3-аас доошгүй ажлын байр шинээр бий болгосон байх.

### **Гурав. Эрчимжсэн аж ахуй эрхлэгч фермерүүдэд тавих шалгуур үзүүлэлт**

3.1. Улсын аварга фермер цолоор шагнуулахаар тодорхойлох эрчимжсэн аж ахуй эрхлэгч нь энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан шаардлагаас гадна дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна:

3.1.1. өндөр ашиг шимт нэг үүлдрийн мал, амьтныг сонгон үржүүлдэг, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний хэмжээ жил дараалан өссөн байх;

3.1.2. тухайн үүлдрийн мал, амьтны арчилгаа маллагааны технологи, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, тоног төхөөрөмжтэй байх;

3.1.3. эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг байх;

3.1.4. мал, амьтны чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанар сайжруулах чиглэлээр шинэ техник, тоног төхөөрөмж, дэвшилтэт арга технологи нэвтрүүлэхэд хөрөнгө оруулалт хийж, тодорхой үр дүнд хүрсэн байх;

3.1.5. саалийн болон махны чиглэлийн аж ахуй эрхлэгч иргэн 20-иос доошгүй га, аж ахуйн нэгж 100-аас доошгүй га газрыг хашиж хамгаалан ногоон тэжээл тариалдаг байх;

3.1.6. үржилд ашиглаж байгаа мал, амьтан бүр удам гарваль, ашиг шимийн бүртгэл хөтөлж мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан тухай баталгаа, үржлийн удам гарвалын гэрчилгээг сумын Хөдөө аж ахуйн тасгаас авсан байх;

3.1.7. өвлийн улиралд саалийн хугацаанд саамын гарцыг тодорхойлж мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан, үндэсний үйлдвэрлэлд нийлүүлсэн байх;

3.1.8. махны үхрийн аж ахуй эрхэлж байгаа иргэн 100, аж ахуйн нэгж 200-аас доошгүй үнээтэй, оны эхний нэг үхрээс 50 кг-аас доошгүй мах үйлдвэрлэж, үйлдвэрлэсэн махны хэмжээ жил дараалан өссөн байх;



3.1.9. махны чиглэлийн хонь үржүүлж байгаа иргэн 300, аж ахуйн нэгж 500-аас доошгүй эм хоньтой, оны эхний нэг хониноос 7.5 кг-аас доошгүй мах үйлдвэрлэж, үйлдвэрлэсэн махны хэмжээ жил дараалан өссөн байх;

3.1.10. гахайн аж ахуй эрхэлж байгаа иргэн 10, аж ахуйн нэгж 60-аас доошгүй үндсэн мэгжтэй, мэгж бүрээс жилд 20-иос доошгүй торой бойжуулж, мах үйлдвэрлэл нь жил дараалан өссөн байх;

3.1.11. өндөглөгч шувуу үржүүлж байгаа өрх, аж ахуйн нэгж нь оны эхэнд 20000-аас доошгүй өндөглөгчтэй, нэг өндөглөгчөөс жилд 280-аас доошгүй өндөг үйлдвэрлэсэн байх;

3.1.12. зөгийн аж ахуй эрхэлж байгаа иргэн 20, аж ахуйн нэгж нь оны эхэнд 100-аас доошгүй бүл зөгийтэй, нэр бүлээс 20 кг-аас доошгүй зөгийн бал үйлдвэрлэсэн байх.

3.2. Мал, гахай, шувуу, зөгийн бүлийн тоо, бүтээгдэхүүний дүнд бусдаас худалдан авсан болон өр төлбөр, бэлгэнд авсан мал, гахай, шувуу, зөгийн бүл, бүтээгдэхүүнийг тооцохгүй.

### **Дөрөв. Шагналд тодорхойлох, шалгаруулах**

4.1. Сумын Засаг даргын Тамгын газар аймаг, нийслэлийн аварга фермерээр шалгарснаас хойш гурваас доошгүй жил амжилтаа тогтвортой хадгалан ажиллаж энэ журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан фермерийг сум, дүүргээс улсын аварга фермерээр тодорхойлж баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн шийдвэр, сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт, хүсэлтийн хамт аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

4.2. Аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага нь сум, дүүргээс ирүүлсэн тодорхойлолт, холбогдох бичиг баримтыг хянаж шаардлага хангасан хамгийн өндөр үзүүлэлттэй нэг фермерийн тодорхойлолтыг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийн хамт жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.3. Улсын аварга фермерээр шалгаруулахаар тодорхойлохдоо дараах бичиг баримт бүрдүүлсэн байна:

4.3.1. фермерийн анкет (Хүснэгт 1-ийн дагуу);



4.3.2. ажлын үзүүлэлтүүд (Хүснэгт 2-4-ийн дагуу);

4.3.3. ажлын үзүүлэлт, тодорхойлолт (Хүснэгт 5-ын дагуу).

4.4. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын аварга фермерээр шалгаруулахаар бүрдүүлж ирүүлсэн тодорхойлолт, материалыг хянан үзэж, шаардлагатай тохиолдолд газар дээр нь шалгаж дүгнэлт гаргана.

4.5. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан хамгийн өндөр үзүүлэлт бүхий 5 хүртэл эрчимжсэн аж ахуй эрхлэгч фермерийн тодорхойлолт, холбогдох материалыг шалгаруулж саналаа зохих журмын дагуу Засгийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлнэ.

4.6. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчийг улсын аварга фермерээр зөвхөн нэг удаа шалгаруулна.

4.7. Энэ журам батлагдахаас өмнө нь улсын тэргүүний фермер болж байсан фермерийг “Улсын аварга фермер”-тэй адилтган үзэх бөгөөд дахин шагнахгүй.

#### **Тав. Шагнал олгох**

5.1. Улсын аварга фермерийг 5.0 (таван) сая төгрөгт багтаан энгэрийн тэмдэг, дурсгалын цом, бусад зүйлээр шагнана.

5.2. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрөөс өмнө гардуулна.



Хүснэгт 1

Цээж зураг

/6x4/-ийн  
хэмжээтэй

УЛСЫН АВАРГА ФЕРМЕРТ ТОДОРХОЙЛОХ  
ИРГЭНИЙ ТОВЧ АНКЕТ

... он ...сар ...өдөр

1.	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр	
2.	Ургийн овог	
3.	Эцэг (эх)-ийн нэр	
4.	Нэр	
5.	Төрсөн он, нас, хүйс	
6.	Боловсрол	
7.	Ам бүлийн гишүүдийн тоо	
8.	Улсад ажилласан жил	
9.	Үүнээс: малчнаар ажилласан жил	
10.	Аймаг, нийслэлийн аварга фермерээр шалгарсан үнэмлэхийн дугаар, огноо	

УЛСЫН АВАРГА ФЕРМЕРТ ТОДОРХОЙЛОХ  
АЖ АХУЙН НЭГЖИЙН ТОВЧ АНКЕТ

.....он.....сар..... өдөр

1.	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр	
2.	Аж ахуйн нэгжийн нэр	
3.	Байгуулагдсан он, сар, өдөр	
4.	Үйл ажиллагааны чиглэл	
5.	Боловсон хүчний мэдээлэл	
6.	Үйл ажиллагаа явуулж байгаа хугацаа	
7.	Аймаг, нийслэлийн аварга фермерээр шалгарсан он, үнэмлэхийн дугаар	
8.	Шагнагдсан төрийн одон, медаль, огноо	



Хүснэгт 2

УЛСЫН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛОХ .....АЙМАГ  
(НИЙСЛЭЛ)-ИЙН .....СУМ (ДҮҮРЭГ)-ЫН СҮҮНИЙ ҮХРИЙН  
АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ ..... -НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

.....он.....сар... өдөр

Үзүүлэлт	Онууд		
	... он	... он	... он
1. Үржүүлж байгаа үхрийн үүлдэр			
2. Оны эхэнд байгаа нийт үхэр (тоо)			
Үүнээс: а/ үнээ (тоо)			
б/ бойжуулсан тугал (тоо)			
3. Үйлдвэрлэсэн нийт сүү (тонн)			
4. Саалийн 305 хоногт нэг үнээнээс саасан сүү (литр)			
5. Үржилд худалдсан үхрийн тоо			
Үүнээс: а/ өсвөр хээлтүүлэгч			
б/ өсвөр хээлтэгч			
6. Бүртгэлд авч баталгаажуулсан цөм сүргийн малын тоо			
7. Зохиомлоор хээлтүүлсэн үнээний тоо			
8. Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тонн)			
Үүнээс: өөрийн хүчээр бэлтгэсэн:			
а/ хүчит тэжээл (тонн)			
б/ дарш (тонн)			
в/ өвс (тонн)			
9. Тэжээлийн ургамал тариалсан нийт талбайн хэмжээ (га)			
а/ хураан авсан нийт тэжээлийн ургамал (цн)			
б/ нэг га-гаас авсан ургац (цн)			
10. Нэг үхэрт зарцуулсан тэжээлийн хэмжээ (тэжээлийн нэгж)			
11. Үхрийн байрны багтаамж (м2)			
12. Ашиглаж байгаа худгийн хүчин чадал (литр/сек)			
13. Оны эцэст тоологдсон нийт үхэр			
Үүнээс: үнээ (тоо)			
14. Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг)			
15. Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
16. Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			
17. Малчны дундаж цалин (мян.төг)			
18. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			

----- сум (дүүрэг)-ын Засаг дарга ----- /...../

Хөдөө аж ахуйн тасгийн дарга ----- /...../



Хүснэгт 3

УЛСЫН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛОХ .....АЙМАГ  
(НИЙСЛЭЛ)-ИЙН.....СУМ (ДҮҮРЭГ)-ЫН МАХНЫ ҮХЭР (ХОНЬ)-ИЙН  
АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ .....-НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

.....он .....сар ..... өдөр

Үзүүлэлт	Онууд		
	....он	.... он	....он
Нэг. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчийн ажлын үзүүлэлт			
1. Үржүүлж байгаа үхэр (хонь)-ийн үүлдэр			
2. Оны эхэнд байгаа нийт үхэр, эсхүл хонины тоо			
Үүнээс: а/ хээлтэгч (тоо)			
б/ хээлтүүлэгч (тоо)			
в/ бойжуулсан төл (тоо)			
3. Үйлдвэрлэсэн нийт мах (тонн)			
4. Оны эхний нэг малаас үйлдвэрлэсэн мах (кг), (нядалгын жингээр)			
5. Зах зээлд борлуулсан нэг үхэр, эсхүл хонины дундаж амьдын жин (кг)			
6. Үржилд худалдсан нийт үхэр, эсхүл хонины тоо			
Үүнээс: а/ өсвөр хээлтүүлэгч			
б/ өсвөр хээлтэгч			
7. Бүртгэлд авч баталгаажуулсан цөм сүргийн тоо			
8. Зохиомлоор хээлтүүлсэн малын тоо			
9. Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тонн)			
Үүнээс: а/өөрийн хүчээр бэлтгэсэн тэжээл (тонн)			
б/ худалдаж авсан тэжээл (тонн)			
10. Тэжээлийн ургамал тариалсан нийт талбайн хэмжээ (га)			
11. Хураан авсан нийт тэжээлийн ургамал (цн)			
12. Нэг га-гаас авсан ургац			
13. Нэг малд зарцуулсан тэжээлийн хэмжээ (тэжээлийн нэгж)			
14. Хашааны багтаамж (м2)			
15. Худгийн хүчин чадал (литр/сек)			
16. Оны эцэст тоологдсон нийт мал			
Үүнээс: а/ хээлтэгч (тоо)			
б/ хээлтүүлэгч (тоо)			
17. Хөрөнгө оруулалт (мян.төг)			
18. Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
19. Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			
20. Нэг ажилтны дундаж цалин (мян.төг)			
21. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			

----- сум (дүүрэг)-ын Засаг дарга ----- /...../  
Хөдөө аж ахуйн тасгийн дарга ----- /...../



Хүснэгт 4

УЛСЫН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛОХ .....АЙМАГ  
(НИЙСЛЭЛ)-ИЙН.....СУМ (ДҮҮРЭГ)-ЫН ГАХАЙ, ШУВУУ, ЗӨГИЙН  
АЖ АХУЙ ЭРХЛЭГЧ ..... -НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

.....он .....сар ..... өдөр

Үзүүлэлт	Онууд		
	...он	...он	...он
Нэг. Гахайчны ажлын үзүүлэлт			
1. Үржүүлж байгаа гахайн үүлдэр			
2. Оны эхэнд байгаа нийт гахайны тоо			
a/ үндсэн мэргийн тоо			
б/ үржилд ашиглах бодонгийн тоо			
в/ бойжуулсан нийт торойн тоо			
г/ нэг мэгжнээс бойжуулсан торой			
3. Үйлдвэрлэсэн нийт гахайн мах (тонн)			
4. Маханд борлуулсан нэг гахайн дундаж амьдын жин (кг)			
5. Үржилд худалдсан шалгалтын мэгжний тоо			
6. Оны эцэст тоологдсон нийт гахай			
Үүнээс: үндсэн мэргийн тоо			
7. Цөм сүргийн гахайны тоо			
8. Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тонн)			
a/ өөрийн хүчээр үйлдвэрлэсэн (тонн)			
б/ худалдан авсан тэжээл (тонн)			
9. Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
10. Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			
11. Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг)			
12. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			

Хоёр. Шувуучны ажлын үзүүлэлт

Үзүүлэлт	Онууд		
	.. он	.. он	.. он
1. Үржүүлж байгаа шувууны үүлдэр			
2. Оны эхэнд байгаа нийт шувууны тоо			
Үүнээс: өндөглөгч шувууны тоо			
3. Нийт үйлдвэрлэсэн өндөг (мян.ширхэг)			
Үүнээс: борлуулсан өндөг (мян.ширхэг)			
4. Бойжуулсан дэгдээхэй			
5. Үржилд худалдсан шувуу			
6. Үйлдвэрлэсэн мах (кг)			
7. Эх сүргийн шувууны тоо			
8. Жилд шаардагдах тэжээлийн нийт хэмжээ (тонн)			
Үүнээс: -өөрийн хүчээр бэлтгэж, үйлдвэрлэсэн (тонн)			
-худалдан авсан тэжээл (тонн)			
9. Оны эцэст байгаа нийт шувуу			



Үүнээс: өндөглөгч шувууны тоо			
10. Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг)			
11. Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
12. Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			
13. Нэг ажилчны дундаж цалин (мян.төг)			
14. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			
Гурав. Зөгийчний ажлын үзүүлэлт			
1. Үржүүлж байгаа зөгийн үүлдэр			
2. Оны эхэнд байгаа нийт зөгийн бүлийн тоо			
3. Нийт үйлдвэрлэсэн зөгийн бал (тонн)			
a/ борлуулсан зөгийн бал (тонн)			
б/ нэг бүлээс хураасан дундаж зөгийн балны хэмжээ (кг)			
4. Үржүүлсэн бүлэнцэр			
5. Үржилд худалдсан зөгийн бүл			
6. Жилд шаардагдах зөгийн тэжээлийн нийт хэмжээ (тонн)			
a/ өөрийн зөгийн балаар тэжээсэн хэмжээ (тонн)			
б/ Худалдан авсан зөгийн тэжээлийн хэмжээ (тонн)			
7. Оны эцэст байгаа нийт зөгийн бүл			
8. Оруулсан хөрөнгө оруулалт (мян.төг)			
9. Жилийн борлуулалтын нийт орлого (мян.төг)			
10. Жилд олсон цэвэр ашиг (мян.төг)			
11. Нэг ажилчны дундаж цалин (мян.төг)			
12. Эрүүл мэнд, нийгмийн даатгалд төлсөн шимтгэл (мян.төг)			

Тайлбар: Үзүүлэлтийг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар шалгаж баталгаажуулна.

----- сум (дүүрэг)-ын Засаг дарга ----- /...../  
Хөдөө аж ахуйн тасгийн дарга ----- /...../

Хүснэгт 5

УЛСЫН АВАРГА ФЕРМЕРЭЭР ТОДОРХОЙЛОХ .....  
АЙМАГ (НИЙСЛЭЛ)-ИЙН ..... СУМ (ДҮҮРЭГ) .....-ЫН  
..... ТОДОРХОЙЛОЛТ

1. Фермерийн ажил байдлын тодорхойлолт;
2. Фермерийн малын А дансны хуулга сүүлийн 3 жилээр;
3. Иргэний үнэмлэхийн хуулбар;
4. Сум, дүүргийн аварга фермер цолны үнэмлэхийн хуулбар;
5. Аймаг, нийслэлийн аварга фермер цолны үнэмлэхийн хуулбар;
6. Малын эрүүл мэндийн дэвтрийн хуулбар;
7. Өрхийн гэр бүлийн гишүүдийн нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;



8. Өрхийн гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн даатгалын дэвтрийн хуулбар;

9. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын газрын тодорхойлолт;

10. Малын индексжүүлсэн даатгалын гэрээний хуулбар;

11. Сум, дүүргийн Хөдөө аж ахуйн тасгийн тодорхойлолт;

12. Сум, дүүргийн Мал эмнэлгийн тасгийн тодорхойлолт;

13. Сум, дүүргийн ИТХ-ын тэмдэглэл, тогтоол;

14. Сум, дүүргийн Засаг даргын албан хүсэлт;

15. Аймаг, нийслэлийн ХХААГазрын шалгаруулалт хийсэн тухай албан бичиг;

16. Аймаг, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр, Засаг даргын албан хүсэлт.

Засгийн газрын 2021 оны 5 дугаар  
тогтоолын 3 дугаар хавсралт

## **УЛСЫН АВАРГА СААЛЬЧИН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Мал аж ахуйн үйлдвэрлэлд тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж, төллөсөн малаа саалинд бүрэн хамруулж, өрхийн үйлдвэрлэлээр хамгийн их сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байгаа саальчны хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Энэ журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан саальчны ажлын үзүүлэлтийг нь үндэслэн улсын аварга саальчнаар шалгаруулна.

1.3. Улсын аварга саальчин шагнал олгох шийдвэрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар гаргана.

### **Хоёр. Шагналд тодорхойлоход тавигдах шаардлага**

2.1. Улсын аварга саальчнаар тодорхойлох саальчин дараахь шаардлагыг хангасан байна:

2.1.1. сүүлийн жилүүдэд тухайн малчин оны эхэнд байсан мал нь бодод шилжүүлснээр 100-аас доошгүй байх бөгөөд 100 хээлтэгчээс бойжуулсан төлийн тоо улсын дунджаас илүү байх;





2.1.2. тухайн саальчны мал сүрэгт эзлэх хээлтэгч мал бог малд 55, бод малд 40-өөс доошгүй хувь байх;

2.1.3. төллөсөн бүх хээлтэгчийг саалинд бүрэн хамруулж, нийт саасан сүүний хэмжээ жил дараалан өссөн байх;

2.1.4. нэг хээлтэгчээс сааж байгаа сүү нь тухайн орон нутагт үржүүлж байгаа үүлдэр, омгийн малын ашиг шимийн дундаж үзүүлэлтээс дээгүүр байх, сүү, цагаан идээгээ зах зээлд борлуулсан байх;

2.1.5. мэргэжлийн байгууллагаас ангилалт хийж удам гарваль, ашиг шимийг нь тогтоосон, стандартын шаардлага хангасан малыг үржилд ашигладаг, малаа сумын мал эмнэлэг үржлийн тасгийн бүртгэлд хамруулсан байх;

2.1.6. ой хээрийн бүсэд хонин толгойд шилжүүлснээр нэг малд 50 кг, өндөр уулын бүсэд 20 кг, тал хээрийн бүсэд 40 кг, говийн бүсэд 5 кг-аас доошгүй өвстэй тэнцэхүйц хадлан, гар тэжээл, өвсөн дарш, хүчит тэжээлийг жил бүр бэлтгэж нөөцөлсөн байх;

2.1.7. мал саах, саалиа боловсруулах арга ажиллагаагаа зааж сурган шавь саальчинтай болсон байх;

2.1.8. мал сүргээ эрүүл байлгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулсан байх;

2.1.9. бэлчээрийн даацад малынхаа тоог тохируулж, сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний дагуу хуваарьтай ашиглаж бэлчээр хамгаалах арга хэмжээ авдаг байх;

2.1.10. үржлийн нэгжээр үржлийн малдаа жил бүр ангилалт хийлгэсэн байх;

2.1.11. таваарын малын 30-аас доошгүй хувийг жил бүр эдийн засгийн эргэлтэд оруулсан байх;

2.1.12. өөрийн ашиглаж байгаа бэлчээрт хортон мэрэгч, шавжтай энгийн механик болон микробиологийн аргаар тэмцсэн байх;

2.1.13. өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржаа, малын хашаа, саравч, худагтай байх.

2.2. Улсын аварга саальчинд эрчимжсэн аж ахуйн саальчныг тодорхойлохгүй.



### **Гурав. Аварга саальчнаар тодорхойлох, шалгаруулах**

3.1. Аймгийн аварга саальчин болсноос хойш хоёроос доошгүй жил амжилттай ажилласан, энэ журамд заасан шаардлага, ажлын үзүүлэлтийг хангасан 1 саальчныг тухайн сумын Засаг даргын Тамгын газраас улсын аварга саальчнаар шалгаруулахаар тодорхойлж, багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн шийдвэр, сумын Засаг даргын тодорхойлолтын хамт аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

3.2. Аймгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага нь сумаас ирүүлсэн улсын аваргад тодорхойлогдсон саальчны холбогдох бичиг баримтыг хянан үзээд аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хамгийн өндөр үзүүлэлттэй нэг хүртэл саальчны тодорхойлолтыг жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.3. Улсын аварга саальчнаар тодорхойлохдоо дараахь бичиг баримтыг бүрдүүлсэн байна:

3.3.1. саальчны товч анкет (Хүснэгт 1-ийн дагуу);

3.3.2. ажлын үзүүлэлт (Хүснэгт 2-ын дагуу);

3.3.3. холбогдох байгууллагын тодорхойлолт (Хүснэгт 3-ын дагуу).

3.4. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын аварга саальчин болгохоор тодорхойлон аймгаас ирүүлсэн саальчдын материалыг саальчин нэг бүрээр хянан үзээд, харьцуулсан дүгнэлт гаргаж, энэ журамд заасан шаардлага, ажлын үзүүлэлтийг хангасан, хамгийн өндөр үзүүлэлт бүхий 6 хүртэлх саальчныг шалгаруулж саналаа зохих журмын дагуу Засгийн газарт оруулж шийдвэрлүүлнэ.

### **Дөрөв. Шагнал олгох**

4.1. Улсын аварга саальчин тус бүрийг 4.0 (дөрвөн) сая төгрөгт багтаан энгэрийн тэмдэг, цолны үнэмлэх, дурсгалын цом, бусад шагналаар шагнана.

4.2. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрөөс өмнө гардуулна.



Хүснэгт 1

УЛСЫН АВАРГА СААЛЧНААР ТОДОРХОЙЛОХ  
ХҮНИЙ ТОВЧ АНКЕТ

.....он.....сар..... өдөр

1.	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр	
2.	Ургийн овог	
3.	Эцэг (эх)-ийн нэр	
4.	Нэр	
5.	Төрсөн он, нас, хүйс	
6.	Боловсрол	
7.	Ам бүлийн гишүүдийн тоо	
8.	Улсад ажилласан жил	
9.	Үүнээс: саальчнаар ажилласан жил	
10.	Төр, засгаас авсан шагнал, огноо	
11.	Аймаг, нийслэлийн аварга саальчнаар шалгарсан он, үнэмлэхийн дугаар	

Хүснэгт 2

УЛСЫН АВАРГА СААЛЧИНД ТОДОРХОЙЛОХ .....АЙМАГ (НИЙСЛЭЛ)  
.....СУМ (ДҮҮРЭГ) -ЫН СААЛЧИН.....-НЫ АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

.....он.....сар..... өдөр

Үзүүлэлт	Малын төрөл (доошгүй байх үзүүлэлт)	Онууд	
		....он	.... он
Нэг. Малын төрөл, тоо			
Малын үүлдэр омог			
1. Оны эхний мал бодод шилжүүлснээр	Бүгд-100		
2. Оны эхний мал	Бүгд		
Үүнээс:	Тэмээ		
	Адуу		
	Үхэр		
	Хонь		
	Ямаа		



3. Хээлтэгч	Бүгд		
Үүнээс:	Ингэ		
	Гүү		
	Үнээ		
	Эм хонь		
	Эм ямаа		
4. Оны эцэст байгаа хээлтэгч	Бүгд		
Үүнээс:	Ингэ		
	Гүү		
	Үнээ		
	Эм хонь		
	Эм ямаа		
5. Бэлтгэсэн тэжээл (тонн)	Өвс		
	Хүчит тэжээл		
	Гар тэжээл		
	Хужир, шүү		
Хоёр. Ашиг шим ашиглалтын байдал			
6. Оны эхний нэг хээлтэгч малаас саалийн хугацаанд саасан сүү (литр)	Бүгд		
Үүнээс:	Нутгийн монгол үнээ		
	Сарлаг		
	Хайнаг		
	Ингэ		
	Гүү		
	Эм хонь		
	Эм ямаа		
7. Боловсруулсан цагаан идээ (тонн)	Бүгд		
	Сүү		
	Ааруул		
	Эззгий		
	Аарц		
	Өрөм		
	Зөөхий		
	Айраг		



	Хоормог		
8. Боловсруулсан цагаан идээнээс олсон орлого (мян. төг)	Бүгд		
	Сүү		
	Ааруул		
	Эзэгий		
	Аарц		
	Өрөм		
	Зөөхий		
	Айраг		
	Хоормог		
9. Хөрөнгө оруулалт	мян.төг		
10. Татвар төлөлт	Төгрөгөөр		
11. Малын даатгал	Даатгуулсан малын тоо		
	Төлсөн хураамж		
12. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Төгрөгөөр		
13. Нийгмийн даатгалын шимтгэл	Төгрөгөөр		

Тайлбар: Дээрх үзүүлэлтүүдийг улсын тооллого, бусад холбогдох материалыг үндэслэн баталгаажуулна. Саасан сүүг малын төрөл тус бүрээр тооцож гаргана.

----- аймаг ----- сумын ----- багийн Засаг дарга  
----- /...../

Хөдөө аж ахуйн тасгийн дарга ----- /...../



УЛСЫН АВАРГА СААЛЬЧНААР ТОДОРХОЙЛОХ .....АЙМГИЙН  
.....СУМЫН .....-ЫН АЖЛЫН ҮЗҮҮЛЭЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Улсын аварга саальчин цолд тодорхойлж байгаа саальчин дараах бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ:

1. Малчны ажил байдлын тодорхойлолт;
2. Малчны малын А дансны хуулга сүүлийн 3 жилээр;
3. Иргэний үнэмлэхийн хуулбар;
4. Сумын аварга саальчин цолны үнэмлэхийн хуулбар;
5. Аймгийн аварга саальчин цолны үнэмлэхийн хуулбар;
6. Малын эрүүл мэндийн дэвтрийн хуулбар;
7. Өрхийн гэр бүлийн гишүүдийн нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;
8. Өрхийн гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн даатгалын дэвтрийн хуулбар;
9. Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын газрын тодорхойлолт;
10. Малын индексжүүлсэн даатгалын гэрээний хуулбар;
11. Сумын Хөдөө аж ахуйн тасгийн тодорхойлолт;
12. Сумын Мал эмнэлгийн тасгийн тодорхойлолт;
13. Сумын ИТХ-ын тэмдэглэл, тогтоол;
14. Сумын Засаг даргын албан хүсэлт;
15. Аймгийн ХХААГазрын шалгаруулалт хийсэн тухай албан бичиг;
16. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэр, Засаг даргын албан хүсэлт.

Засгийн газрын 2021 оны 5 дугаар  
тогтоолын 4 дүгээр хавсралт

## **УЛСЫН АВАРГА ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН, УЛСЫН АВАРГА ТАРИАЛАНЧ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Хөрс хамгаалах дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж эрчимжүүлэх, нэгжээс хураан авах ургац, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах болон нийгэмд оруулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хувь нэмрийг урамшуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журмын шаардлагыг хангасан 12 хүртэл ахуйн нэгжийн сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг нь үндэслэн “Улсын аварга тариаланч хамт олон”-оор, 21 иргэнийг сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлтийг нь үндэслэн “Улсын аварга тариаланч”-аар тус тус шалгаруулна. Үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжид ажиллаж байгаа тракторч-комбайнчийг Улсын аварга тариаланч”-аар шалгаруулж болно.

1.3. Улсын аварга тариаланч хамт олон, улсын аварга тариаланчаар шалгаруулан шагнах асуудлыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

### **Хоёр. Шагналд тодорхойлоход тавигдах шаардлага**

2.1. Улсын аварга тариаланч хамт олон, Улсын аварга тариаланчаар шалгаруулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь 10-аас дээш жил тариалангийн үйлдвэрлэл тогтвортой эрхэлсэн байх;

2.1.2. хамт олон нь жил бүр усалгаатай нөхцөлд үр тариа, малын тэжээлийн ургамал 250 га, усалгаагүй нөхцөлд үр тариа, малын тэжээлийн ургамал 500 га, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ 10 га, иргэн нь усалгаатай нөхцөлд үр тариа, малын тэжээлийн ургамал 50 га, усалгаагүй нөхцөлд үр тариа, малын тэжээлийн ургамал 100 га,

төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ 0.5 га-аас доошгүй талбайд тус тус тариалалт хийж ургац хураан авсан байх;

2.1.3. сүүлийн 3 жил дараалан жил бүр га тутмаас хураан авсан үр тарианы ургац нь усалгаагүй талбайд 15 цн-ээс, усалгаатай талбайд 30 цн-ээс, төмсний ургац нь усалгаагүй талбайд 160 цн-ээс, усалгаатай талбайд 200 цн-ээс, малын тэжээлийн ургац нь усалгаагүй талбайд 30 цн-ээс, усалгаатай талбайд 60 цн-ээс доошгүй байх;

2.1.4. сүүлийн 3 жил дараалан жил бүр га тутмаас байцаа 250 цн-ээс, үндэс үрт ногоо 180 цн-ээс, сонгинолог ургамал 120 цн-ээс, хамгаалагдсан хөрсний 1 метр квадрат талбай тутмаас өргөст хэмх 18 кг, улаан лооль 12 кг, гүзээлзгэнэ 2 кг, навчит ногоо 2 кг-аас доошгүй ургац хураан авсан байх;

2.1.5. сүүлийн 3 жил дараалан жил бүр комбайнаар шууд хураалтад шилжүүлснээр 400 га, трактораар 1200 жишмэл га-аас доошгүй ажил гүйцэтгэсэн байх;

2.1.6. хөрсний үржил шимийг хамгаалах, чийгийн хуримтлалыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн, үр тарианы үйлдвэрлэлд уриншийн эзлэх хувийн жинг багасгаж, тэжээлийн ургамлыг сэлгээнд оруулсан байх;

2.1.7. үр тарианы үйлдвэрлэл эрхлэгчид нь эргэлтийн талбайгаа 100 хувь ашиглаж, дараа оны тариалалтад зориулан хүрэлцэхүйц хэмжээний чанар сайтай үр нөөцөлсөн байх;

2.1.8. аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийж, шинээр ажлын байр бий болгох, ажиллагчдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан байх;

2.1.9. татвар, хураамж болон газрын төлбөрийг хугацаанд нь төлсөн байх;

2.1.10. хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний газартай болж техникийн бэлэн байдал, хангамжийг сайжруулсан байх.



## **Гурав. Тодорхойлолт бүрдүүлэх, шалгаруулах**

3.1. Аймаг, нийслэлийн аварга тариаланч хамт олон, аварга тариаланчаар шагнагдсанаас хойш хоёроос доошгүй жил амжилтаа тогтвортой хадгалан ажиллаж, энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан тариаланч хамт олон, тариаланчийг “Улсын аварга тариаланч хамт олон”, “Улсын аварга тариаланч”-аар шалгаруулахаар тодорхойлно.

3.2. Улсын аварга тариаланч хамт олон, улсын аварга тариаланчаар шалгаруулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэний тодорхойлолт, холбогдох материалыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор багтаан аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

3.3. Аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллага нь сум, дүүргээс ирүүлсэн тодорхойлолт, материалыг хянаж аймаг, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэн, хамгийн өндөр амжилт гаргасан гурав хүртэлх аж ахуйн нэгж, байгууллага, тав хүртэлх тариаланчийн тодорхойлолт, холбогдох материалыг жил бүрийн 01 дүгээр сарын 05-ны дотор хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4. Улсын аварга тариаланч хамт олон, улсын аварга тариаланчаар шалгаруулахаар тодорхойлохдоо дараах материалыг бүрдүүлнэ:

3.4.1. тариаланчийн товч анкет (Хүснэгт 1-ийн дагуу);

3.4.2. сүүлийн 3 жилийн ажлын үзүүлэлт (Хүснэгт 2-ын дагуу);

3.4.3. аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэний үнэмлэхийн хуулбар;

3.4.4. аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ажил байдлын талаарх сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт;

3.4.5. сум, дүүрэг, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын тогтоол, санал дүгнэлт, аймаг, нийслэлийн Засаг даргын хүсэлт;

3.4.6. харилцагч татварын байгууллагын тодорхойлолт, орлогын татвар төлөлтийн баримт;

3.4.7. аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан байгууллагаас хөрс хамгаалах талаар авсан арга хэмжээ, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн тухай тодорхойлолт, шалгаруулах үзүүлэлтийг газар дээр нь шалгасан дүгнэлт.

3.5. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дүнд бусдаас худалдан авсан болон өр төлбөрт авсан бүтээгдэхүүнийг оруулж тооцохгүй.

3.6. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь улсын аварга тариаланч хамт олон, улсын аварга тариаланчаар шалгаруулахаар ирүүлсэн материалыг хянан үзэж, шаардлагатай гэж үзвэл газар дээр нь шалгаж дүгнэлт гаргана. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг ажлын үзүүлэлтээр нь байр эзлүүлэн энэхүү журмын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан хамгийн өндөр үзүүлэлт бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг шалгаруулан шагнуулах саналаа Засгийн газарт хүргүүлж шийдвэрлүүлнэ.

3.7. Энэ журам батлагдахаас өмнө “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, “Улсын тэргүүний тариаланч” шагналаар шагнагдаж байсан хамт олон, иргэнийг “Улсын аварга тариаланч хамт олон”, “Улсын аварга тариаланч”-тай адилтган үзнэ.

3.8. Иргэнийг “Улсын аварга тариаланч”-аар зөвхөн нэг удаа шалгаруулна.

3.9. Аж ахуйн нэгж, байгууллага “Улсын аварга тариаланч хамт олон” шагналаар шагнагдсанаас хойш үзүүлсэн амжилтаа 3-аас дээш жил тогтвортой хадгалсан бол уг аж ахуйн нэгж, байгууллагыг “Улсын аварга тариаланч хамт олон”-оор дахин шалгаруулахаар тодорхойлж болно.

### **Дөрөв. Шагнал олгох**

4.1. Улсын аварга тариаланч хамт олон тус бүрийг 5.0 (таван) сая төгрөгт багтаан, өргөмжлөл, дурсгалын цом, туг, үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүн, улсын аварга тариаланч тус бүрийг 3.0 (гурван) сая төгрөгт багтаан энгэрийн тэмдэг, үнэмлэх, мөнгөн цар, бусад зүйлсээр шагнана.

4.2. Шагналыг билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрөөс өмнө гардуулна.



Хүснэгт 1

Цээж зураг

/6x4/-ийн  
хэмжээтэй

УЛСЫН АВАРГА ТАРИАЛАНЧААР  
ТОДОРХОЙЛЖ БАЙГАА ИРГЭНИЙ  
ТОВЧ АНКЕТ

.....он...сар...өдөр

1.	Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр	
2.	Ургийн овог	
3.	Эцгийн /эх/ нэр	
4.	Нэр	
5.	Төрсөн он, нас, хүйс	
6.	Боловсрол	
7.	Ам бүлийн гишүүдийн тоо, тэдний эрхэлж байгаа ажил	
8.	Улсад ажилласан нийт хугацаа, хийж байсан ажил	
9.	Тариаланчаар ажилласан хугацаа	
10.	Төр, засгаас авсан шагнал, огноо	
11.	Аймгийн тэргүүний тариаланчаар шалгарсан он, үнэмлэхийн дугаар	



УЛСЫН АВАРГА ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН, УЛСЫН АВАРГА  
ТАРИАЛАНЧААР ШАЛГАРУУЛАХ СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	Онууд			Тайлбар
	... он	... он	... он	
1. Тариалангийн эргэлтийн талбай (га)				
Үүнээс: а/ тариалсан				
б/ уриншилсан				
2. Таримлын төрөл				
3. Хураан авсан ургац, нэр төрлөөр (тонн)				
Үүнээс: а/ нөөцөлсөн үр (тонн)				
б/ зах зээлд борлуулсан ургац (тонн)				
4. Нэг га-ийн ургац, нэр төрлөөр (тарьсан талбай цн-ээр)				
Үүнээс: а/ усалгаатай талбайгаас (цн)				
б/ усалгаагүй талбайгаас (цн)				
5. Нийт борлуулалт (сая.төг)				
Үүнээс: а/ төлсөн татвар (сая.төг)				
б/ даатгалд (сая.төг)				
6. Ашиг (сая.төг)				
7. Ажлын байрны тоо				
8. Нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн орлого (мян.төг)				
9. Трактораар гүйцэтгэсэн ажил, жишмэл га-аар				
10. Комбайнаар хураасан талбай, шууд хураалтад шилжүүлсэн га-аар, авсан ургац тонноор				

Тайлбар: Энэ хүснэгтэд зөвхөн сүүлийн 3 жилийн тариалангийн үзүүлэлтийг бичнэ. Шагнагдах үндэслэлийн талаар тодорхойлолтод дэлгэрэнгүй бичиж, холбогдох байгууллагын тодорхойлолтыг үзүүлэлт тус бүрээр бүрдүүлж ирүүлсэн байна. Дээрх хүснэгтийн 9, 10-т заасан ажлын хэмжээ нь зөвхөн тракторч-комбайнчид хамаарна.



Үзүүлэлтийг гаргасан:

Сум, дүүргийн Засаг дарга -----(.....)

Мэргэжилтэн -----(.....)

Хянаж баталсан:

Аймаг, нийслэлийн Хөдөө аж ахуй

хариуцсан байгууллагын дарга----- (.....)

Мэргэжилтэн -----(.....)

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medeel@parliament.mn

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 2.75

**Индекс: 200003**